



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/112/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорнод аймаг

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа

Утас: 70584207 Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	111
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	123
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	134
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	155
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	156
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.19 № 98

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520022



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Эрдэнэбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв. Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 50 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх”

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчны тэнцвэрт байдлыг хамгаалах
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 20 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,417,908.9 мянган төгрөгөөс тооцон 28,378.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 13,908.5 мянган төгрөгөөр тооцсон болно. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг түвшин өндөр байгаа нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал өмнөх онд аймгийн ИТХ-аар батлагдаж урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд нэмэгдэж ирсэнтэй холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,362.2 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	67,578.0	74,703.4	7,125.4
Үндсэн хөрөнгө	232,342.9	234,842.8	2,499.9
Хуримтлагдсан элэгдэл	-126,347.1	-147,334.6	-20,987.5
Нийт хөрөнгө	173,573.7	162,211.5	11,362.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	173,573.7	162,211.5	11,362.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	173,573.7	162,211.5	11,362.2

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос нэмэгдсэн нь 2449,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо буурсан нь тайлант үеийн үр дүнд элэгдлийн зардал нөлөөлснөөс шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орлого бүрдүүлдэг байгууллага биш тул орлогын төлөвлөгөө тусгагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулан 426,249.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 426,249.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 426,249.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төлөвлөжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 99.6 хувьтай байна



Нэмэлт төсөв: Аймгийн байгаль хамгаалах сан болон дэлхийн байгаль хамгаалах сангуудаас 256,315.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосныг 100.0 хувь зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 20 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 20 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 50473,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 473.9 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 41,260.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,740.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг тус тус өглөө.

Аудитаар дараах 50,473.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 41,733.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас ажилчдын хүүхдүүдэд 300.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, МУИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолтой нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байдал, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Татварын цахим e-barimt.mn сайтаар худалдан авалтыг тулган баталгаажуулахад үйл ажиллагаанд хамааралгүй 173.9 мянган төгрөгийн бараа материалыг төсвөөс худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байдал, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Нийт худалдан авалтын 88.7 хувь буюу 41.3 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь Е-баримтад бүртгэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.



2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 127,598.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвөөс үйл ажиллагаанд хамааралгүй бараа материал худалдан авч, зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

1.2 Эрсдэл: Дотоод хяналт муу, төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах.

1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

2. МУЕА-аас өгсөн чиглэл

2.1. Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтын тооцооны анхан шатны баримтад жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтөлдөггүй, ирсэн явсан цаг хугацаа байхгүй, спидометрийн заалт бичдэггүй, тооцоог бүрэн боддоггүй байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67 578 025,12	74 703 425,12
35	БАРАА МАТЕРИАЛ	67 578 025,12	74 703 425,12
351	Түүхий эд материал	39 021 904,64	39 021 904,64
35110	Тусгай зориулалттай материал	39 021 904,64	39 021 904,64
354	Хангамжийн материал	28 556 120,48	35 681 520,48
35410	Бичиг хэргийн материал	313 600,00	234 000,00
35420	Аж ахуйн материал	27 148 030,48	28 648 030,48
35470	Бусад хангамжийн материал	1 094 490,00	6 799 490,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105 995 644,30	87 508 046,68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	105 995 644,30	87 508 046,68
391	Газар	00,00	00,00
392	Биет хөрөнгө	105 995 644,30	87 508 046,68
39201	Барилга, байгууламж, орон сууц	5 000 000,00	5 000 000,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2 499 999,60	-2 749 999,56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112 378 760,00	112 378 760,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-60 619 417,25	-74 759 820,99
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50 499 650,00	52 999 640,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32 879 950,51	-36 170 514,39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7 764 530,00	7 764 530,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4 722 928,30	-5 204 548,30
39214	Бусад үндсэн хөрөнгө	33 900 000,00	33 900 000,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2 825 000,04	-5 650 000,08
39303	Бусад биет бус хөрөнгө	22 800 000,00	22 800 000,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-22 800 000,00	-22 800 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	173 573 669,42	162 211 471,80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	173 573 669,42	162 211 471,80
51	Засгийн газрын хувь оролцоо	173 573 669,42	162 211 471,80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	65 759 520,00	65 759 520,00
51101	Өмч: - төрийн	65 759 520,00	65 759 520,00
512	Хуримтлагдсан үр дүн	107 707 185,42	96 344 987,80
51210	Өмнөх үеийн үр дүн	107 707 185,42	107 707 185,42
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	-11 362 197,62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	106 964,00	106 964,00



6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	173 573 669,42	162 211 471,80
---	--	-----------------------	-----------------------

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 437 670 900,00	684 062 829,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 057 000,00	1 498 000,00
120	Нийтлэг татварын бус орлого	3 057 000,00	1 498 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00,00	1 498 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	1 498 000,00
120009	Бусад орлого	3 057 000,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 434 613 900,00	682 564 829,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61 230 000,00	256 315 229,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	595 000,00	17 714 720,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60 635 000,00	238 600 509,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1 373 383 900,00	426 249 600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1 373 383 900,00	426 349 600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1 417 908 920,62	695 425 026,62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 417 908 920,62	695 425 026,62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 319 970 909,62	633 611 917,62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287 746 373,00	303 434 797,00
210101	Үндсэн цалин	278 599 873,00	292 589 297,00
210102	Нэмэгдэл	00,00	1 000 000,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 146 500,00	9 845 500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35 022 068,00	38 718 570,00
210201	Тэтгэврийн даатгал	23 513 118,00	24 482 733,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 301 888,00	5 209 283,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 877 360,00	1 961 325,00
210204	Ажилгүйдлийн даатгал	575 468,00	1 026 108,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5 754 234,00	6 039 121,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4 120 901,00	3 075 707,00
210301	Гэрэл, цахилгаан	00,00	69 801,00
210302	Түлш, халаалт	3 504 201,00	3 005 906,00
210303	Цэвэр, бохир ус	00,00	00,00
210304	Байрны түрээс	616 700,00	00,00



210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	7 172 639,00	11 012 991,00
210401	Бичиг хэрэг	934 378,00	1 333 100,00
210402	Тээвэр, шатахуун	5 193 030,00	8 740 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	801 670,00	939 891,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	243 561,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 095 000,00	1 628 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00,00	83 000,00
210604	Урсгал засвар	3 095 000,00	1 545 000,00
2107	Томилолт, зочны зардал	3 287 000,00	6 347 700,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	3 287 000,00	6 347 700,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	834 800,00	1 060 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	55 000,00	250 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	300 000,00	300 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118 800,00	38 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11 000,00	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350 000,00	450 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	978 692 128,62	268 334 152,62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	953 711 143,00	247 346 565,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24 980 985,62	20 987 587,62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97 938 011,00	61 813 109,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14 242 500,00	17 311 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14 242 500,00	14 370 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	2 941 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83 695 511,00	44 501 209,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83 695 511,00	44 501 209,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>19 761 979,38</u>	<u>-11 362 197,62</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>19 761 979,38</u>	<u>-11 362 197,62</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1 437 670 900,00</u>	<u>684 062 829,00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>3 057 000,00</u>	<u>1 498 000,00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	<u>3 057 000,00</u>	<u>1 498 000,00</u>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00,00	1 498 000,00



1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	1 498 000,00
120009	Бусад орлого	3 057 000,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 434 613 900,00	682 564 829,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61 230 000,00	256 315 229,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	595 000,00	17 714 720,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60 635 000,00	238 600 509,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1 373 383 900,00	426 249 600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1 373 383 900,00	426 249 600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1 402 670 900,00	684 062 829,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 402 670 900,00	684 062 829,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 304 732 889,00	622 249 720,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287 746 373,00	303 434 797,00
210101	Үндсэн цалин	278 599 873,00	292 589 297,00
210102	Нэмэгдэл	00,00	1 000 000,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 146 500,00	9 845 500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36 059 533,00	38 718 570,00
210201	Тэтгэврийн даатгал	24 550 583,00	26 764 219,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 301 888,00	2 994 494,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 654 224,00	1 844 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	798 604,00	866 318,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5 754 234,00	6 249 339,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4 120 901,00	3 075 707,00
210301	Гэрэл, цахилгаан	00,00	69 801,00
210302	Түлш, халаалт	3 504 201,00	3 005 906,00
210304	Байрны түрээс	616 700,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	7 486 239,00	10 933 391,00
210401	Бичиг хэрэг	1 247 978,00	1 253 500,00
210402	Тээвэр, шатахуун	5 193 030,00	8 740 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	801 670,00	939 891,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	243 561,00	00,00
2105	Нормативт зардал	10 500 900,00	1 500 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10 500 900,00	1 500 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 095 000,00	3 582 990,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00,00	2 582 990,00
210604	Урсгал засвар	3 095 000,00	1 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	3 287 000,00	6 347 700,00
210702	Дотоод албан томилолт	3 287 000,00	6 347 700,00



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	834 800,00	1 060 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	55 000,00	250 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	300 000,00	300 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118 800,00	38 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11 000,00	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350 000,00	450 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	951 602 143,00	253 596 565,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	951 602 143,00	253 596 565,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97 938 011,00	61 813 109,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14 242 500,00	17 311 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14 242 500,00	14 370 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	2 941 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83 695 511,00	44 501 209,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83 695 511,00	44 501 209,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35 000 000,00	00,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35 000 000,00	00,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35 000 000,00	00,00
2200	Дотоод эх үүсвэрээр	35 000 000,00	00,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35 000 000,00	00,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-35 000 000,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65 759 520,00	106 964,00	107 707 185,42	173 573 669,42



D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65 759 520,00	106 964,00	107 707 185,42	173 573 669,42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65 759 520,00	106 964,00	107 707 185,42	173 573 669,42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-11 362 197,62	-11 362 197,62
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65 759 520,00	106 964,00	96 344 987,80	162 211 471,80

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428 249 600,00	427 747 600,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428 249 600,00	427 747 600,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410 878 700,00	368 653 155,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339 008 300,00	303 434 797,00
210101	Үндсэн цалин	304 632 600,00	292 589 297,00
210102	Нэмэгдэл	21 775 700,00	1 000 000,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12 600 000,00	9 845 500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44 487 300,00	38 718 570,00
210201	Тэтгэврийн даатгал	30 259 500,00	26 764 219,00
210202	Тэтгэмжийн даатгал	3 561 000,00	2 994 494,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 842 200,00	1 844 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	708 600,00	866 318,00
210205	Эрүүл мэндийн даатгал	7 116 000,00	6 249 339,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	3 603 600,00	3 075 707,00



	зардал		
210301	Гэрэл, цахилгаан	225 600,00	69 801,00
210302	Түлш, халаалт	3 378 000,00	3 005 906,00
2104	Хангамж, бараа материалын зардал	10 997 900,00	10 933 391,00
210401	Бичиг хэрэг	1 253 500,00	1 253 500,00
210402	Тээвэр, шатахуун	8 740 000,00	8 740 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 004 400,00	939 891,00
2105	Нормативт зардал	1 500 900,00	1 500 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 500 900,00	1 500 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 583 000,00	3 582 990,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2 583 000,00	2 582 990,00
210604	Урсгал засвар	1 000 000,00	1 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	6 347 700,00	6 347 700,00
210702	Дотоод албан томилолт	6 347 700,00	6 347 700,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 350 000,00	1 060 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250 000,00	250 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	300 000,00	300 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300 000,00	38 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50 000,00	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450 000,00	450 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17370900,00	17311900,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17 370 900,00	17 311 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14 370 900,00	14 370 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3 000 000,00	2 941 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	430 249 600,00	427 747 600,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	425 249 600,00	00,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	425 249 600,00	00,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3 000 000,00	426 249 600,00
132001	Орон нутгийн төсвөөс	3 000 000,00	426 249 600,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2 000 000,00	1 498 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 000 000,00	1 498 000,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35,00	35,00
620001	Удирдах ажилтан	01,00	01,00
620002	Гүйцэтгэх ажилтан	31,00	31,00
620003	Үйлчлэх ажилтан	03,00	03,00
620004	Гэрээт ажилтан	00,00	00,00